



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 8 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- | | |
|---------|--|
| Дарга | -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга |
| Гишүүд: | -Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;
-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
-Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын захирал;
-Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын дарга;
-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
-Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
-Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга; |

-Монгол Улсын Шадар сайдын зөвлөх;

-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын зөвлөх;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөх.

Нарийн
бичгийн дарга:

-Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх.

2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулж 2016 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (Ж.Мөнхбат)-т даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Ж.МӨНХБАТ